

ХӨГЖЛИЙН АЗИ ЗАГВАР БОЛ БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧУХАЛ ХӨШҮҮРЭГ МӨН

*Л.ХАЙСАНДАЙ**

Хорьдугаар зууны эхний хагаст дэлхийн хоцрогдсон бүс нутгийн нэг байсан Ази тив өнөдөр хүн төрөлхтний хөгжлийг тодорхойлох хэмжээнд хүртлээ хөгжсөн байна. Ялангуяа Зүүн болон Зүүн өмнөд Азийн орнууд богино хугацаанд хөгжлийн өндөр түвшинд хүрч бусад ард түмэнд үлгэр дуурнал болж байгааг та бид мэднэ.

Дэлхийн 2-р дайны дараа Азийн эдийн засаг бүхэлдээ уналтанд орсон байв. Ихэнх судлаачид Азийн эдийн засаг сэргэхэд олон арван жил хэрэгтэй гэж үзэж байлаа. Гэтэл 1950-иад он гэхэд Японы эдийн засаг хөл дээрээ босч цаашид найдвартай хөгжих гараагаа эхэлсэн.

1970-аад оноос Тайвань, Хонконг, Сингапур, Өмнөд Солонгос эрчимтэй хөгжлийн замдаа орж "Азийн дөрвөн бар" хэмээн нэрлэгдэх болсон. 1980-аад оноос Малайз, Тайваньд, Индонезийн, 1990-ээд оноос Хятад, Вьетнамын эдийн засаг түргэн өсөлттэйгөөр хөгжиж байна. Бидэнтэй нэг тивд амьдарч буй эдгээр орны эдийн засаг богино хугацаанд түргэн хурдацтай хөгжиж чадсаны нууц юу вэ? Мэдээжээр олон зүйл нөлөөлсөн боловч доорхи 3 үндсэн хүчин зүйл хамгийн чухал ач холбогдолтой байсан гэж үзэж болно.

Үүнд: Нэгдүгээр хүчин зүйл. Эдийн засгийн цаашдын хөгжилд чухал холбогдолтой тэргүүний технологийг гадаадаас импортлох замаар нэвтрүүлсэн явдал юм. Дайны дараах жилүүдээс Япон нь Америкийн технологийг импортолж эхэлсэн. Дараа нь Япон технологи импортлогч орноос экспортлогч орон болсон байна.

1970-аад оноос Тайвань, Хонконг, Өмнөд Солонгос, Сингапур зэрэг орон нэхмэл, металлурги, цахилгаан техникийн үйлдвэрлэлийн технологийг Японоос импортолж эхэлжээ. 1980-аад оны эхээс Азийн дөрвөн бар технологи экспортлогч орнууд болов. Эдгээр орны ахуйн цахилгаан техник, нэхмэл, нефть, химийн үйлдвэрлэлийн технологийг Малайз, Тайланд, Индонез, Филиппин, Хятад, Вьетнамд нэвтэрүүлж эхэлсэн. Ийнхүү тэргүүний технологийг амжилттай нэвтэрүүлсэн.

Хоёрдугаар хүчин зүйл. Хөгжлийн Англи-Саксон загвараас ялгагдах гол онцлог нь эдгээр орны хөгжилд төрийн зохицуулалт чухал ач холбогдолтой байсан явдал юм.

* Л.Хайсандай - доктор, профессор

1960-аад оноос Өмнөд Солонгосын Засгийн газар эдийн засгийг хөгжүүлэх тав, таван жилийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ирлээ.

Хятадын засгийн газар шилжилтийн эдийн засгийн бодлогын гол зарчмаа "Гол руу орохдоо чулуун дээр болгоомжтой гишгэх хэрэгтэй" гэж тодорхойлсон байна.

Эдгээр орны эдийн засгийн хөгжилд улс төрийн гарамгай удирдагчид их хувь нэмэр оруулсан юм. Энд Японы Ёшида, Сингапурын Ли Куан Ю, Тайваний Ли Тохки, Өмнөд Солонгосын Пак Жон Хи, Малайзын Махатхир, Хятадын Дэн Сяопин нарыг зүй ёсоор дурдах учиртай.

Гуравугаар хүчин зүйл. Энэ бүс нутгийн ард түмэн бол их хөдөлмөрч хүмүүс. Ямар ч үед байнгын нөр хичээнгүй хөдөлмөрлөх чадвар төлөвшсөн байдаг. Энэ бол хөгжлийн маш чухал хүчин зүйл. Цуцалтгүй хөдөлмөрлөнө гэдэг бол баян болно гэсэн үг, боловсролтой, соёлтой болно гэсэн үг.

Аливаа улс орны өөдлөн дэгжих, уруудан доройтохын аль аль нь хүнээсээ шалтгаалдаг байна. Чухамдаа хөгжлийн гурван гол урсгал байгаагийн нэгдэх нь хүнийг баримжаалсан / буюу хүн төвтэй/ үзэл, нөгөөдөх нь технологи баримжаалсан, гуравдах нь хоёулангийн нь аж төрөхийг хөгжил гэдэг юм.

Үүнээс үзэхэд хөгжилтэй орон гэж *нэгдүгээрт*, хүнээ хөгжүүлж чадсан орныг, *хоёрдугаарт*, үндэсний төгөлдөр технологи эзэмшсэн орныг, *гуравдугаарт*, нэг хүнд өндөр орлого ноогдохоор нь баримжаалдаг байна.

Дүгнэж хэлэхэд, улс орны хөгжин дэвших, ахуй амьдрал нь баян чинээлэг болох явдал чухамхүү хүн ардын нь боловсрол мэдлэг, ажилсаг чанар, төр засгийн нь зөв цэгцтэй бодлогын үр шимээс шалтгаалдаг болохыг дээр дурдсан Азийн орнуудын хөгжлийн замнал, туршлага харуулж байна.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн тогтолцоонд шилжих шилжилт нь анхны үр дүнд хүрч, эргэлт буцалтгүй болсон авч шинэ шинэ сорилт бэрхшээлтэй алхам дутамд тулгарсаар байгаа манай Монголын шинэтгэлийн үйл явцын олон арван асуудлын хариуг Зүүн Азийн орнууд, тухайлвал Солонгос, Сингапур, Тайвань гэх мэт жижиг орны шилжилтийн загвараас олж харж болно.

Ийм үзэл баримтлалын үүднээс энэ орнуудын эдийн засгийн шинэтгэл, шилжилтийг Зүүн европын орнуудынхтай харьцуулж үзвэл

хэд хэдэн онцлог бүхий бөгөөд харьцангуй илүү үр дүнтэй байна. Тиймд "Шинэчлэлт шилжилтийн Ази загвар" хэмээн томъёолж тодорхойлж болно.

Хятад, Монгол, Вьетнамд төрийн үүрэг ямархуу байгааг хөрш зэргэлдээх капиталист орнуудтай нь харьцуулж үзсэн, Зүүн Азийн орнууд социалист элемент бүхий капиталист замаар хөгжсөн болохоор ийм харьцуулалт бас хэрэгтэй юм. Эдгээр орны банкууд улсын мэдэлд буюу улсын хяналтан дор үйл ажиллагаагаа явуулдаг, улсын мэдлийн үйлдвэр, аж ахуйн газрын тоо харьцангуй олон /ялангуяа Тайваньд /, хувийн аж ахуйтны хэрэгт улс хөндлөнгөөс оролцох нь их байдаг. Тэгэхлээр Хятад, Япон, Солонгос, Вьетнам, Монгол, Тайванийг капиталист зах зээлийн орон болон төвлөрсөн төлөвлөгөөт социалист эдийн засагтай орнуудын хүрээнд багтдаг гэж хэлж болохоор байна. Төлөвлөгөөт болон зах зээлийн эдийн засаг Зүүн Азийн капиталист системд зэрэгцэн оршиж байгаа нь шилжилтийн үеийн тун ч ашигтай загвар байж болох юм гэдэгтэй Азий болон Зүүн Европын төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай байсан орны эрдэмтэд, эдийн засагчид санал нэгтэй байдаг. Төрийн үүргээс гадна тухайлбал, хөгжлийн бусад хэмжүүр болдог хөрөнгийн хуримтлал /иргэдийн хадгаламж, гадаадын шууд хөрөнгө оруулалт, мөнгө зээлэх гэх мэт/, мөн экспортын үүргийг энд бас тэмдэглэх ёстой.

Эрдэмтдийн судалгаанаас үзэхэд Азид эдийн засгийн хөгжил, шилжилтийн Хятад, Японы гэх мэт том орны Солонгос, Тайвань, Вьетнам, Монгол зэрэг жижиг орны загвар байж болох юм.

Том орны хөгжлийн загварт экспортын чиг баримжаа бага, дотоодын үйлдвэрлэлд их төлөв түшиглэж, төлбөрийн балансыг илүү чухалчилдаг зэрэг онцлог талууд байна. Хятадын нүсэр том эдийн засгийн өсөлт, шилжилтийн одоогийн байдал, төлөв нь Япон мэтийн томоохон улсын загварыг дагаж байхад харин Вьетнам, Монгол зэрэг жижиг улсын шилжилтийн арга зам нь экспортын чиг баримжааг эрхэмлэдэг, гадаадын хөрөнгө оруулалтанд илүү найдаж, төлбөрийн балансыг нэг их чухалчилдаггүй Солонгос мэтийн жижиг орны загвартай илүү төстэй онцлогуудтай байна.

Монгол улс бол "Шилжилтийн замаар хөгжиж байгаа жижиг орон". Тиймд нэгд, жижиг орны хувьд Монгол улс Солонгос, Тайваний нэгэн адил гадагш чиглэсэн экспортын баримжаатай өсөлтийн хэв загварыг авч хэрэглэвэл зохистой бөгөөд тэгж ч байна. Энд нэг чухал зүйл гэвэл Олон улсын хэмжээнд өрсөлдөж чадахуйц экспортын

үйлдвэрлэл бий болгох явдал юм. Хүн ам цөөнтэй болохоор хүн хүчний олноор бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх уламжлалт бололцоо хязгаарлагдмал байна. Иймд хүнсний болон эрдэс баялагийн анхан шатны боловсруулалтанд үндэслэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь илүү тохиромжтой. Хоёрт, аж үйлдвэрийн бүтэц, ажил эрхлэлтийн тухайд бол цаашдаа ХАА-аас аж үйлдвэрийн салбарт ажиллах хүч шилжих хандлага зонхилох төлөвтэй. Гуравт, Монгол улс хөгжлийнхөө тусын тулд гадаадын хөрөнгө оруулалтанд ихээхэн найдлага тавьж чадахгүй ч гэсэн төлбөрийн балансаа зохицуулж болохуйц зохицтой хэмжээнд байлгах нь чухал. Дөрөвт, эдийн засаг хожуу ч гэсэн зах зээлд шилжиж, зах зээлийн үүрэг өсөн нэмэгдэхэд төрийн үүрэг ч үлэмж чухал болно.

Эдгээр нь үндсэндээ Зүүн хойт Азийн олон талын хамтын ажиллагааны чухал хүчин зүйл болж байна.